



**ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА,
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ
ХҮРЭЭЛЭН**

ХӨГЖЛИЙН ШИЙДЭЛ ТББ

**ЭДИЙН ЗАСГИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ
10 ИХ НАЯДЫН БОДЛОГЫН
ХУВИЙН СЕКТОРТ ҮЗҮҮЛСЭН
ҮР НӨЛӨӨ БА ХЭРЭГЖИЛТИЙН СУРГАМЖ**

Хэлэлцүүлгийн тайлан

**УЛААНБААТАР ХОТ
2022 ОН**

Гарчиг

Оршил	3
1. Хэлэлцүүлгийн зохион байгуулалт	3
2. Хэлэлцүүлгээр хөндсөн асуудлууд	5
Хавсралтууд.....	9

Оршил

Хөгжлийн шийдэл ТББ, Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн ТББ (ЭЗСЭШХ) хамтран хэрэгжүүлж буй “ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО: ӨНГӨРСӨН БА ИРЭЭДҮЙ” нэгдсэн форум зохион байгуулах ажлын эхний үе шатыг амжилттай хэрэгжүүллээ.

Эхний үе шатанд дараах зорилтуудыг тавьсан. Үүнд:

1. “Эдийн засгаа эрчимжүүлэх хөтөлбөрийн хувийн секторын үр нөлөө, сургамж” сэдэвт судалгааны ажил хийх
2. Дээрх судалгааны урьдчилсан үр дүнд суурилсан хэлэлцүүлгийг хөтөлбөрийн оролцогч талуудыг хамруулан зохион байгуулж, судалгаанд шаардлагатай нэмэлт мэдээллийг цуглуулах
3. Судалгаа болон хэлэлцүүлгээс гарах гол дүгнэлт, саналыг боловсруулж, нэгдсэн форумд танилцуулах илтгэлийн гол агуулгыг бэлтгэх


ЭЗСЭШХ эхний зорилт болох “Эдийн засгаа эрчимжүүлэх хөтөлбөрийн хувийн секторын үр нөлөө, сургамж” сэдэвт судалгааны ажлын урьдчилсан тайланг 2022 оны 5-р сарын 25-нд бэлтгэж захиалагчид хүргүүлсэн. Тус хөтөлбөрийн талаарх нийтэд нээлттэй мэдээлэл дутагдалтай, байгаа мэдээлэл нь нэлээд хуучин байсан тул эхний хэлэлцүүлгийн үеэр оролцогч талуудаас тус хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн талаар бодитой, шинэ мэдээлэл олж авахыг зорьсон. Хэлэлцүүлгийн үеэр болон бусад үед цуглуулсан нэмэлт мэдээлэлд үндэслэн дээрх судалгааны тайланг шинэчилж, энэхүү хэлэлцүүлгийн тайлантай хамт захиалагчид хүргүүлэв.

Эхний шатны хэлэлцүүлэг болох “Эдийн засгаа эрчимжүүлэх хөтөлбөрийн хувийн секторын үр нөлөө, сургамж” хэлэлцүүлгийн зохион байгуулалт үр дүнгийн талаар тайлангийн дараах хэсгүүдэд дурдана.

1. Хэлэлцүүлгийн зохион байгуулалт

“Эдийн засгаа эрчимжүүлэх хөтөлбөр буюу 10 их наядын цогц төлөвлөгөөний ЖДҮ салбарын үр нөлөө ба сургамж” сэдэвт хэлэлцүүлгийг 2022 оны 6-р сарын 17-нд Улаанбаатар хотод Блю Скай зочид буудалд зохион байгуулав. Хэлэлцүүлэгт тус хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагууд, зарим холбоодын төлөөлөл болон хувиараа бизнес эрхлэгч нийт 42 хүн оролцсон. Хэлэлцүүлэгт ирсэн зочдын 43% нь төрийн байгууллагын төлөөлөл байсан бол нийт оролцогчдын 31% нь хувиараа бизнес эрхлэгчид байжээ.

Зураг 1. Хэлэлцүүлэгт оролцогчид, байгууллагын төрлөөр, хувиар



Төрийн байгууллагууд буюу Сангийн яам, Монголбанк, ХНХЯ, Жижиг дунд үйлдвэрийн газар, Зээлийн батлан даалтын сан гэх мэт 7 байгууллагын төлөөлөл 21 хүн урьснаас 18 хүн оролцжээ. Санхүүгийн байгууллагууд буюу хөнгөлөлттэй зээл олгож буй арилжааны 7 банкны төлөөлөл урьснаас 3 банкнаас хэлэлцүүлэгт ирсэн. Нийт 25 хувиараа бизнес эрхлэгчдийг хэлэлцүүлэгт урьсны 13 нь оролцон, өөрийн санал хүсэлтээ илэрхийлсэн. Мөн Оёдлын салбарын мэргэжлийн нэгдсэн холбоо, Хог хаягдал дахин боловсруулагчдын үндэсний холбоо зэрэг төрийн бус байгууллагыг төлөөлж 8 хүн оролцжээ. Хэлэлцүүлэгт нийт 66 зочин урьснаас 42 буюу 64% нь оролцон, мэдээлэл хуваалцаж, санал хүсэлтээ илэрхийлжээ. Нийт оролцогчдын 22 нь буюу 52% нь эрэгтэй байв.

Хүснэгт 1. Хэлэлцүүлэгт оролцогчдын ирц ба бүтэц

№	Байгууллагууд	Ирсэн хүний тоо	Урьсан хүний тоо	Ирцийн хувь
1	Төрийн байгууллагууд	18	21	86%
2	Санхүүгийн байгууллагууд	3	7	43%
3	Төрийн бус байгууллагууд	8	17	47%
4	Хувиараа бизнес эрхлэгчид	13	21	62%
	Нийт	42	66	64%

Хэлэлцүүлгийн үеэр хувиараа бизнес эрхлэгчид болон зарим холбоодын төлөөлөл хөтөлбөрийг зохион байгуулагчдаас асуулт асууж, зарим санал, шүүмжээ илэрхийлсэн. Нийт 9 хүн санал, хүсэлтээ илэрхийлэн, тодруулга асуулт асуусан нь нийт оролцогчдын 21% байв (Хэлэлцүүлэгт оролцогчдын дэлгэрэнгүй бүртгэлийг Хавсралт 1-ээс үзнэ үү).

Хэлэлцүүлгийн хөтөлбөрийг анх төлөвлөхдөө 3 дэд сэдвээр панел хэлэлцүүлэг хийхээр зорьсон. Үүнд, “Ажлын байрыг дэмжих зээл ба жижиг дунд бизнес”, “10 их наядын цогц төлөвлөгөө ба банкны салбарын оролцоо”, “10 их наядын цогц төлөвлөгөө ба ХАА, томоохон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид” гэсэн сэдвийг сонгож, гол төлөв цогц төлөвлөгөөний хэрэгжилтэд оролцсон төрийн байгууллагуудын мэдээлэл, байр суурийг түлхүү сонсох сонирхолтой байсан. Гэвч дэд сэдэв бүрд панелистаар оруулахаар урьсан төрийн байгууллагууд панел хэлбэрээр оролцохоос татгалзаж, мэдээлэл танилцуулга хийх болон ердийн асуулт хариулт хэлбэрээр оролцох боломжтойгоо илэрхийлсэн. 10 их наядын цогц төлөвлөгөөг хэрэгжилтэд оролцсон төрийн байгууллагууд, арилжааны банкууд хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарах, олон нийтийн шүүмжлэлд өртөхөөс болгоомжилж хэлэлцүүлэгт орохоос татгалзах байдал ажиглагдсан. Мөн ихэнх байгууллага удирдах албан тушаалтнаа биш, мэргэжилтнүүдээ хэлэлцүүлэгт оролцуулах хариу өгсөн.

Иймээс хэлэлцүүлгийн дараалал, форматыг өөрчилж, “Ажлын байрыг дэмжих зээл ба жижиг дунд бизнес”, “10 их наядын цогц төлөвлөгөө ба банкны салбарын оролцоо” гэсэн хоёр дэд сэдвийн хүрээнд 5 байгууллагын төлөөлөл танилцуулга хийж, модератор хоёр хэлэлцүүлгийг ердийн асуулт хариултын хэлбэрээр удирдан явуулсан. Хэлэлцүүлгийн шинэчилсэн хөтөлбөрийг Хавсралт 2-оос үзнэ үү.

Хэлэлцүүлгийн модератороор эдийн засагч Д.Жаргалсайхан ажиллав.

2. Хэлэлцүүлгээр хөндсөн асуудлууд

Хэлэлцүүлгийн эхэнд “Хөгжлийн шийдэл” ТББ-ын ерөнхий менежер Л.Төгсбаяр өөрсдийн хэрэгжүүлж буй BEST хөтөлбөр, түүний хүрээнд хэрэгжүүлж буй ЖДБ салбарыг дэмжих үйл ажиллагаагаа танилцуулсан. Хөтөлбөрийн дагуу хэлэлцүүлэгт 5 байгууллага холбогдох танилцуулга бэлтгэж илтгэл тавьсан. Илтгэлүүдийн гол агуулгыг эхлээд товч дурдъя. Илтгэлүүдийг бүрэн эхээр нь Хавсралт 3-аас үзнэ үү.

Эхний илтгэлийг ЭЗСЭШХ-ийн ахлах судлаач З.Манлайбаатар “Эдийн засгаа эрчимжүүлэх хөтөлбөр буюу 10 их наядын цогц төлөвлөгөөний хувийн секторын үр нөлөө, сургамжийн талаарх тойм судалгаа” сэдвээр хийсэн. Энд тус цогц төлөвлөгөөний хүрээнд олгосон хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрүүдийн хамрах хүрээ, хэрэгжилтийг 2021 оны 8-р сарын байдлаар танилцуулж, цогц төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнгийн талаар бусад байгууллагын хийсэн үнэлгээг нэгтгэн тоймлосон. Мөн цогц төлөвлөгөөний арга хэмжээнээс үүдэж макро эдийн засгийн үзүүлэлтүүдэд гарсан байж болох өөрчлөлтүүдийн талаарх таамаглалыг дэвшүүлсэн.

Хоёр дахь илтгэлийг ЖДҮГ-ын Бодлого зохицуулалтын хэлтсийн дарга А.Гэрэлзаяа “Цар тахлын үеийн ЖДҮГ-аас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр нөлөө” сэдвээр тавьсан. Илтгэлд ЖДҮҮ-ний салбарын хууль эрх зүйн орчин, төрөөс дэмжих бодлогын чиглэл, Ковидын үед тус салбарт төрөөс хэрэгжүүлсэн арга хэмжээ, 10 их наяд цогц төлөвлөгөөний хүрээнд Ажлын байрыг дэмжих 2 их наяд төгрөгийн зээлийн статистик, ЖДҮ Хөгжүүлэх Сангийн 2009-2020 оны зээл олголтын талаар мэдээлэл өгч, ЖДҮГ-аас энэ чиглэлд хэрэгжүүлж буй сүүлийн үеийн ажлаасаа танилцуулав.

Гурав дахь илтгэлийг Нийслэлийн ЖДҮҮДТ НӨҮГ-ын Төсөл хөтөлбөр, инновацийн хэлтсийн дарга М.Мөнхжаргал “Цар тахлын үеийн нийслэлийн ЖДҮҮ-ний салбарын нөхцөл байдал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ” сэдэвт илтгэл танилцуулсан. Илтгэлд нийслэлд үйл ажиллагаа явуулж буй ЖДҮҮ-ний салбарын ерөнхий статистик мэдээ, тус төвийн хэрэгжүүлж буй үйл ажиллагааг танилцуулснаас гадна, 2021 оны 4-5-р сард гүйцэтгэсэн цар тахлын үеийн нийслэлийн ЖДҮҮ эрхлэгчдийн нөхцөл байдлын талаарх түүвэр судалгааны үр дүнгээс хуваалцсан.

Дөрөв дэх илтгэлийг Монголбанкны Судалгааны хэлтсийн захирал Б.Дуламзаяа “Эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн-2021” илтгэлийг танилцуулсан. Илтгэлд уг цогц төлөвлөгөөний зээл, санхүүжилтийн арга хэмжээний 2021 оны эцсийн байдлаарх хэрэгжилтийг зээлийн хөтөлбөр тус бүрээр нарийвчлан танилцуулсан. Мөн тус цогц төлөвлөгөө хэрэгжихийн өмнөх ба дараах үеийн эдийн засгийн нөхцөл байдлыг харьцуулж, тус төлөвлөгөөний эдийн засагт үзүүлсэн нөлөөллийн талаарх Монголбанкны судлаачдын хийсэн үнэлгээ дүгнэлтийг хүргэсэн.

Тав дахь илтгэлийг ЗБДС-ийн ахлах мэргэжилтэн М.Баярмаа “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааны танилцуулга” илтгэл тавьсан.

Эдгээр илтгэлийн дундуур “Ажлын байрыг дэмжих зээл ба жижиг дунд бизнес”, “10 их наядын цогц төлөвлөгөө ба банкны оролцоо” сэдэвт хэлэлцүүлгийг модератор хөтлөн явуулав. Энэ үеэр Ажлын байрыг дэмжих зээлд хамрагдахад аж ахуйн нэгжүүдэд НӨАТ төлөгч байх, сүүлийн 6 сар үйл ажиллагаа явуулсан байх зэрэг шаардлага тавьж байгаа нь хэр үндэслэлтэй талаар оролцогчид байр суурь илэрхийлсэн. Мөн ЖДҮҮ эрхлэгчдэд тулгарч буй нийтлэг суурь асуудлуудыг өргөн хүрээнд ярилцсан. Харин банкны салбарын төлөөлөл цөөхөн хамрагдсан, идэвх муутай оролцсон тул тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх үед банкны салбарт тулгарсан асуудлуудын талаар хэлэлцээгүй.

Тус хэлэлцүүлгийн үеэр санал бодлоо хэлсэн хүмүүсийн яриаг дор товчлон сийрүүлэв.

Оёдлын салбарын мэргэжлийн нэгдсэн холбооны ерөнхийлөгч Энхзаяа: “Ковидын үед тус салбарын орлого 67-80 хувь буурсан. Зээлийн шалгуур үзүүлэлтүүд зөв зохистой байсан. НӨАТ-ын хувьд бүх аж ахуйн нэгжүүдэд тэгш үйлчлэх ёстой. Бичил, жижиг аж ахуйн нэгжүүд НӨАТ төлдөггүй, дунд аж ахуйн нэгжүүд НӨАТ төлдөг нь шударга биш. Иймээс НӨАТ-ын түвшнийг 3-5% болгоод бүх компаниудыг жигд хамруулбал шударга болно. Татвар өндөр байгаа нь татвар төлөхөөс зайлсхийх хандлагыг нэмэгдүүлж байна. НӨАТ төлөгч компаниуд үйлдвэрлэлийнхээ орцыг НӨАТ төлдөггүй компаниудаас авсан тохиолдолд НӨАТ-ын буцаалт авч чадахгүй болно. Жишээ нь, зах, худалдааны төвүүдийн худалдаа эрхлэгчид и-баримтаар худалдаа хийхээс зайлсхийдэг. Үүнээс болоод ЖДҮҮ эрхлэгчдийн хасагдах зардал буурч, ашигтай болж харагдаад татвар их төлөхөд хүрдэг. Мөн нийгмийн даатгалын хувь хэмжээ нэмэгдсэн. Ажил олгогчийн төлөх НДШ нь өндөр насны тэтгэвэр биш, үйлдвэрийн осол, эрүүл мэндийн даатгалыг хариуцдаг байх нь оновчтой. Нэг шүүмжлэлтэй асуудал бол Ажлын байр дэмжих зээлийг зөвхөн эргэлтийн хөрөнгөд олгоно гэсэн. Оёдлын салбарт энэ нь даавуу. Улирлаас хамаараад материал нь өөр өөр. Гэтэл зээл судалсан банкны мэргэжилтнүүд үүнийг ойлгохгүй, даавуу бол даавуу, та эргэлтийн хөрөнгөтэй учраас танд зээл өгөхгүй гэж үздэг. Тэгээд та репо ав гэдэг. Өөр нэг компанийн жишээ гэвэл, 100 саяын зээл судалж шийдээд 50 саяыг 3 хувийн зээл, үлдсэнийг нь өөрсдийн эх үүсвэрээс арилжааны зээл ав гэж тулгасан. ЖДҮҮ эрхлэгчдэд тоног төхөөрөмжийн зээл их хэрэгцээтэй байдгийг бас анхаарах хэрэгтэй”.

“Бүрэн арцат” ХХК-ийн захирал Батхишиг: Том компаниуд ЖДҮҮ-ээс хэр их худалдан авалт хийдэг вэ? Том нь жижгээ тэтгэж чирж явдаг. ЖДҮҮ эрхлэгчид ямар багтаамжтай зах зээлд, ямар хүмүүстэй өрсөлдөж байгаа мэдээлэлгүйгээр зах зээл рүү орж байна. Яг нэг чиглэлийн олон компанид зээл өгөхөөр цөөхөн нь л амжилттай, бусад нь бүтэлгүйддэг. Мэдээлэл шаардлагатай. ЖДҮҮ эрхлэгчид дор дороо тэр мэдээллийг олж авч чадахгүй, зардал ихтэй. Харин ЖДҮҮ газар, эсвэл салбарын холбоод, МҮХАҮТ тийм нэгдсэн мэдээллээр хангаж өгвөл олон мянган ЖДҮҮ эрхлэгчдийн зардлыг хэмнэсэн, эрсдэлийг бууруулсан чухал ажил болохоор байна.

ЖДҮГ-ын дарга А. Гэрэлзаяа: “Том бизнесүүд жижиг бизнесээ дэмжих сайн жишээнүүд байдаг. Жишээ нь Газар шим компани хүнсний ногоо худалдаж авах, Тэсо компани ямааны сүү авах, Дархан Нэхий компани “Увсын цагаан улт” гутлын загвар дизайн боловсруулах гэх мэт. Уул уурхайн төсөл, төрийн худалдан авалт дээр ЖДҮҮ-г дэмжих бодлого байгаа. ЖДҮГ “Эх оронч худалдан авалт” гэсэн арга хэмжээний хүрээнд томоохон аж ахуйн нэгжүүдээс дотоодын худалдан авалтын мэдээллээ гаргаж өгөхийг хүсдэг, нөгөө талд нь ЖДҮҮ эрхлэгчид өөрсдийн чадавх, түвшнийг харуулсан үзэсгэлэн худалдаа зохиодог, энэ хоёр талыг уулзуулах ажил зохион байгуулдаг. ЖДҮГ-ын пэйж хуудас шинэчлэгдэж байгаа, тэнд чухал мэдээллүүд оруулдаг болж байгаа”

Монголын хог хаягдлыг боловсруулах үндэсний холбооны тэргүүн Батжаргал: “ЖДҮҮ эрхлэгчдэд олгодог янз бүрийн хөнгөлөлттэй зээлийн арга хэмжээнд хог хаягдал боловсруулах үйлдвэрүүд хамрагддаггүй, зөвшөөрөгдөх чиглэлд нь хамаардаггүй. Мөн хаягдал боловсруулдаг газрууд цуглуулсан түүхий эддээ и-баримт авдаггүй, тийм боломж байхгүй. Иймээс хог хаягдал боловсруулах салбарыг яг ХАА-н гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрүүдтэй адил нэмэгдэл өртөг шингэсэн гэж тооцож хөнгөлөлт үзүүлдэг байх хэрэгтэй байна”.

ЖДҮГ-ын дарга А. Гэрэлзаяа: ЖДҮХС сүүлийн жилүүдэд төсвөөс санхүүжилт аваагүй, эргэн төлөлтөөрөө санхүүжиж байгаа. 2022 онд 20.5 тэрбум төгрөг төвлөрнө, үүний 10 тэрбумыг нийслэлд, 10.5 тэрбумыг орон нутагт зээлээр олгоно. Өнгөрсөн жил хүнсний үйлдвэрлэл, халдвар хамгааллын чиглэлд түлхүү зээл олгосон бол энэ онд зээлийн 90% хүнсний хангамжид чиглэнэ. Хэрвээ төсөв нэмэгдвэл бусад салбаруудад зээл олгоно.

Монголын жижиглэн худалдаа эрхлэгчдийн холбооны Нарантуяа: “Цар тахлын 2 жилийн хугацаанд барааны үнийн өсөлт, үйл ажиллагаанд тавигдсан хязгаарлалт, барааны тасалдал зэрэг хүндрэл тулгарсан. НӨАТ их дарамт болдог учраас НӨАТ-ын түвшнийг 5% болгох шаардлага гаргаж, татварын алба, Засгийн газарт олон удаа хандсан. Татварын энэ дарамтыг тус тусдаа яриад байвал үр дүнгүй, салбарын олон холбоод, аж ахуйн нэгжүүд нэгтгэж, хүчтэй шаардлага тавьж хүргэх хэрэгтэй. НӨАТ-д бүртгэлгүй хүчин чадал багатай жижиг худалдаа эрхлэгчид ихэнх нь Ажлын байрыг дэмжих зээлд хамрагдаж чадаагүй, тиймээс энэ хөтөлбөрийг үр нөлөө муутай болсон гэж дүгнэж байна.”

Модератор Д.Жаргалсайхан: “Монголын 100 мянга гаруй компанийн 6 мянга нь л МҮХАҮТ-ын гишүүн. Тус танхим 100 гаруй ажилтантай, дээр дурдсан мэдээллүүдийг гаргаж өгдөг. Тэр мэдээллийг гишүүн бус байгууллагууд авч чадахгүй байгаа. Өрсөлдөх чадварын суурь нь мэдээлэл. Мэдээлэлгүйгээс болоод хоорондоо үнээрээ өрсөлдөөд хүнд байдалд ордог. Жишээ нь, манай цементийн үйлдвэр. 4 том үйлдвэр гадаадын зээлээр боссон, гэвч зээлээ төлж чадахгүй асуудал босож ирсэн. 1997-2000 онд манай Гадаадын хөрөнгө оруулалтын газар 7 хоног бүрд аль салбарт ямар компани бүртгүүлж байгаа мэдээллийг гаргадаг байсан. Одоо энэ мэдээлэл гарахгүй байгаа. Үүнээс болоод жишээлбэл махны салбар бүхэлдээ Хятадын компаниудын мэдэлд орсон. Ийм явдлаас сэргийлэхийн тулд мэдээллийг нээлттэй болгох, салбарын холбоод, танхим эрх мэдэлтэй байх, шаардлага тавьдаг байх хэрэгтэй. Европын орнууд шиг бүх компани автоматаар танхимын гишүүн болдог байх хэрэгтэй. 30 мянган төгрөг төлөөд гишүүн болдог байж болно. Худалдааны танхим шилдэг татвар төлөгч шалгаруулах нь оновчтой биш байна. Компанийн зорилго бол татвар төлөх биш, ашиг олох. Шилдэг татвар төлөгчийн оронд дотоодоос хамгийн их дүнгээр худалдан авалт хийсэн, эсвэл худалдан авалтынхаа хамгийн их хувийг дотоодоос хийсэн компаниудыг шалгаруулдаг байвал үр дүнтэй болно. Мөн дотоодоос худалдан авалт хийх Засгийн газрын шийдвэр хэрэгждэггүй тухай шүүмж гарсан. Жишээ нь тавилгыг дотоодоос авч болно. Энэ чухал шийдвэр яагаад хэрэгждэггүй байгааг Засгийн газар анхаарах хэрэгтэй”.

ЭЗСЭШХ-ийн захирал Б.Түвшинтөгс: “10 их наядын цогц төлөвлөгөө нь хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл олгож байгаа, зах зээл дээр бол ийм хямд зээл олгогдохгүй. Иймээс нийт зээл ихээр тэлсэн. Хүмүүсийн худалдан авалт эрс нэмэгдсэн. Гэтэл нөгөө талд Хятадын хил хязгаарлагдмал байна. Иймээс 15% инфляцид хүрсэн. Дэлхий даяар бодлого боловсруулагчид яг ийм асуудалтай тулгарсан. Мөнгөний нийлүүлэлтийг бууруулья гэвэл зээл олгохгүй болно. Бас төсвийн зардлыг бууруулна. Инфляцийг бууруулахын тулд эдийн засгаа унагах ёстой хэцүү сонголттой болоод байна. Ингээд Монголбанк бодлогын хүүгээ өсгөсөн, энэ нь зээлийн хүү өснө гэсэн үг, ингэхээр зээл авч байгаа төслүүд буурна, зээл буурна, эдийн засгийн идэвхжил буурна. Биднээс хамаарал багатай хил гаалийн хүндрэл гол шалтгаан болж байна. ЖДҮ салбартай холбоотой нэг гол зүйл бол төрөөс агентлаг байгуулж байгаад зээл олгох нь зөв тогтолцоо юу гэдэг асуултад хэн ч хариулаагүй байгаа. Өмнөх явж ирсэн тогтолцоогоо л дагаад байгаа, өөрчлөөгүй. Нэг хэсэг ЖДҮХС-ийн чанаргүй зээлийн хувь 50% хүрсэн. Арилжааны банкнаас цэвэр арилжааны нөхцөлтэй бүтээгдэхүүн гаргаж байхад зэрэгцээд хөнгөлөлттэй зээл төрөөс олгодог тогтолцоо гарч ирсэн нь зарчмын хувьд буруу. Арилжааны ашиг сонирхлыг яаж холбож өгөх вэ гэдэг нь шийдэгдээгүй. Бидний хувьд ийм хөнгөлөлттэй зээл гэхээсээ, төрийн хувьд ЖДҮ салбарт тулгардаг хэлцлийн зардал гэгдэх их хэмжээний, шаардлагагүй, төвөг чирэгдэл учруулдаг зардлуудыг онилж бодлого явуулах нь илүү үр дүнтэй гэж манай байгууллагын нэг судалгаанаас гарсан”.

Маяара трэйд компанийн захирал Азжаргал “10 их наядын хөтөлбөрийн үр өгөөжийг ЖДҮ эрхлэгчид бид олж харсангүй. Сүүлийн үед бараа, түүхий эд өссөн учраас зардал нэмэгдсэн, нөгөө талд борлуулалтынхаа үнийг нэмж чадахгүй байгаа, хүмүүсийн худалдан авах чадвар муудсан. Дэлхий даяар үнэ өсөж байхад манай улсад үүний эсрэг бодлого алга, үйлдвэрлэгч нар хамгийн их хохирч байна. Дээр нь түүхий эд татах гэхээр банкнууд доллар гаргахгүй

байна. Сүлжээ дэлгүүрүүд үйлдвэрлэгчдээс их хэмжээний хувь нэхдэг, энэ нь Худалдааны хууль байхгүйтэй холбоотой. Ийм юмнуудаа арга хэмжээ авахгүй бол дараагийн том цунами хаяанд ирлээ. Үйлдвэрлэгчид түүхий эдийн хязгаарлалтад орлоо.”

Агъшим компанийн захирал Давхарбаяр: “ЖДҮҮ эрхлэгчид зээл авахдаа түүхий эд материал, тоног төхөөрөмж, түрээсийн байрандаа л авдаг. Тоног төхөөрөмжөө ойр, хямдаар нь Хятадаас л авдаг. Гэтэл хил гаалийн хязгаарлалтаас болоод тоног төхөөрөмжөө авч чадахгүй болоод байна. Хязгаарлалтгүй байлаа ч бас яг таарах тоног төхөөрөмж олох хэцүү байдаг. Иймээс зарим үйлдвэрлэгч тоног төхөөрөмжөө өөрсдөө хийх асуудал тулгардаг. Шинжлэх ухаан, инновацийн үйл ажиллагаагаар төрийн сектор үйлдвэрлэгчдийг дэмжиж болох юм. Яг мөнгө зээл өгөхөөс илүү дотоодын ийм боломжтой нөөцтэй газруудыг хооронд нь холбох, уялдуулан зохицуулах үйл ажиллагааг төр, танхим, мэргэжлийн холбоод хийж болох юм. Бартер солилцооны мэдээллийн платформ байж болох юм”

Модератор Д.Жаргалсайхан: “Маш чухал дүгнэлтүүд байна. Энд төрийн оролцоо хэт ихсэж байгаа тухай суурь асуудлыг зайлшгүй дурдах ёстой. Маш олон агентлагийн нэрээр хувийн секторын хийж болох зүйлсийг төр хийдэг, гэхдээ хариуцлага бараг хүлээхгүй. Жишээ нь, Төрийн банк маш их өртэй, гэхдээ өндөр цалинтай олон захирал томилогддог. Улс төрийн нөлөөгөөр тэр албан тушаалууд дээр хүмүүс томилдог. Дээр нь халамж их байна. Хоёрдугаарт үнийг чөлөөлж, өрсөлдөөнийг нээмээр байна. Компаниуд зардлаараа өрсөлдөх ёстой. Төр үнийг хямдруулна гэж буруу бодлого хэрэгжүүлж байна. Дараагийн гол асуудал бол газар гэх нийтийн өмчийн хулгай их том бэрхшээл учруулж байна. Ер нь ийм суурь асуудлуудыг шийдэхгүйгээр компанид тулгарч буй ганц хоёр асуудлаар тус тусдаа яриад юу ч бүтэхгүй гэдэг нь харагдаж байна”.

Хавсралтууд